

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/081/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/183
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Р.ГЭРЭЛСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөг, дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.3 мянган төгрөг, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай” 01/301 дугаартай зөвшөөрлийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 23,869.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчилж 16,709.9 мянган төгрөгөөр тогтоон бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

4176020178

**Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 93.0 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	231,619,019.50	246,775,892.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	191,281,001.88	210,610,583.41
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	191,281,001.88	210,610,583.41
3121	Төгрөг	191,281,001.88	210,610,583.41
31211	Төрийн сангийн харилцах	191,281,001.88	210,610,583.41
35	БАРАА МАТЕРИАЛ	40,338,017.62	36,165,309.04
354	Хангамжийн материал	40,338,017.62	36,165,309.04
35410	Бичиг хэргийн материал	667,400.00	346,500.00
35420	Аж ахуйн материал	3,940,000.00	1,140,500.00
35470	Бусад хангамжийн материал	35,730,617.62	34,678,309.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	868,083,444.64	880,199,949.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	868,083,444.64	880,199,949.47
392	Биет хөрөнгө	839,358,064.64	851,011,597.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	715,461,762.95	715,461,762.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(88,834,652.43)	(105,042,973.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	263,716,137.01	279,362,380.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,470,651.75)	(111,277,177.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,514,261.10	102,579,531.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,509,667.12)	(34,783,290.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,571,270.40	5,135,136.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,510,045.52)	(843,421.32)
39217	Ном	419,650.00	419,650.00
393	Биет бус хөрөнгө	28,725,380.00	29,188,352.00
39301	Програм хангамж	903,360.00	632,352.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(733,980.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	28,556,000.00	28,556,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,099,702,464.14	1,126,975,841.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,232,509.57	5,564,326.11
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,232,509.57	5,564,326.11
413	Өглөг	12,232,509.57	5,564,326.11
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	265,730.99	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,872,600.00
4136	Бусад өглөг	11,966,778.58	3,691,726.11
41361	Байгууллагад төлөх өглөг	11,966,778.58	3,691,726.11
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,087,469,954.57	1,121,411,515.81
51	Засгийн газрын хувь оролцоо	1,087,469,954.57	1,121,411,515.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	212,812,268.15	212,812,268.15
51101	Өмч: - төрийн	184,256,268.15	184,256,268.15
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	28,556,000.00	28,556,000.00

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	301,650,922.56	337,554,403.80
51210	Өмнөх үеийн үр дүн	301,650,922.56	303,612,842.56
51220	Тайлант үеийн үр дүн	-	33,941,561.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	573,006,763.86	571,044,843.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,099,702,464.14	1,126,975,841.92

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,580,204,526.04	1,689,469,194.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,003,126.04	53,879,094.47
120	Нийтлэг татварын бус орлого	102,003,126.04	50,029,730.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,003,126.04	2,506,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	266,000.00	2,506,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	91,737,126.04	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		40,427,875.14
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		7,095,855.69
122	Тусламжийн орлого	-	3,849,363.64
122002	Хандив тусламж /гадаад/	-	3,849,363.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,478,201,400.00	1,635,590,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,310,319,200.00	1,474,335,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,310,319,200.00	1,474,335,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	167,882,200.00	161,254,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	167,882,200.00	161,254,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,390,481,175.85	1,648,869,073.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,390,481,175.85	1,648,869,073.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,342,505,609.56	1,577,594,285.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	918,209,852.12	1,129,621,714.81
210101	Үндсэн цалин	428,878,876.43	668,807,689.72
210102	Нэмэгдэл	449,934,175.69	390,160,764.66
210104	Урамшуулал	39,396,800.00	70,653,260.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,545,435.06	132,702,905.67
210201	Тэтгэврийн даатгал	66,154,004.01	89,707,968.49
210202	Тэтгэмжийн даатгал	9,342,773.72	11,088,464.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,454,829.96	5,562,384.45
210204	Ажилгүйдлийн даатгал	4,290,257.10	5,070,742.69
210205	Эрүүл мэндийн даатгал	20,303,570.27	21,273,345.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,448,019.71	155,983,981.30
210301	Гэрэл, цахилгаан	8,827,094.69	11,808,383.30
210302	Түлш, халаалт	140,763,425.02	140,095,598.00
210303	Цэвэр, бохир ус	4,857,500.00	4,080,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,662,528.00	42,815,195.27
210401	Бичиг хэрэг	-	12,468,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	5,605,811.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,055,480.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	12,205,820.00
210408	Бараа материал акталсны зардал	5,662,528.00	9,479,484.27
2105	Нормативт зардал	19,459,900.00	29,860,000.00

**Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	19,459,900.00	29,860,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,832,100.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	12,832,100.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,811,828.58	13,352,547.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	266,000.00	2,506,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,545,828.58	10,846,547.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,535,946.09	68,257,940.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,665,243.06	8,576,667.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,020,940.00	20,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,849,763.03	59,661,173.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,975,566.29	71,274,787.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,373,486.00	71,004,069.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,899,460.00	52,110,051.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,474,026.00	18,894,018.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	602,080.29	270,718.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	602,080.29	270,718.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	189,723,350.19	40,600,121.24
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,315,500.00	6,658,560.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	6,658,560.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,315,500.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,315,500.00)	(6,658,560.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	185,407,850.19	33,941,561.24

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,488,667,400.00	1,638,096,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,466,000.00	2,506,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,466,000.00	2,506,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,266,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	266,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	2,506,000.00
120009	Бусад орлого	200,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,478,201,400.00	1,635,590,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,310,319,200.00	1,474,335,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,310,319,200.00	1,474,335,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	167,882,200.00	161,254,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	167,882,200.00	161,254,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,312,936,660.57	1,584,442,518.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,312,936,660.57	1,584,442,518.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,265,201,840.28	1,514,902,375.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	917,785,727.54	1,129,606,359.81
210101	Үндсэн цалин	597,707,882.92	668,807,689.72
210102	Нэмэгдэл	278,207,638.60	390,145,409.66
210104	Урамшуулал	41,870,206.02	70,653,260.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,206,714.65	132,968,636.66
210201	Тэтгэврийн даатгал	69,445,922.89	89,707,968.49
210202	Тэтгэмжийн даатгал	9,449,496.41	11,354,195.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,482,699.11	5,562,384.45
210204	Ажилгүйдлийн даатгал	4,147,719.68	5,070,742.69
210205	Эрүүл мэндийн даатгал	15,680,876.56	21,273,345.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	154,448,019.71	155,983,981.30
210301	Гэрэл, цахилгаан	8,522,883.70	12,415,069.30
210302	Түлш, халаалт	141,067,636.01	140,128,912.00
210303	Цэвэр, бохир ус	4,857,500.00	3,440,000.00
2105	Нормативт зардал	19,105,750.00	27,987,400.00
210502	Хоол, хүнс	19,105,750.00	27,987,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,832,100.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	12,832,100.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,418,170.58	25,305,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	266,000.00	2,506,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,152,170.58	22,799,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,405,357.80	38,050,398.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,877,817.80	31,353,198.00

**Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,527,540.00	6,697,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,734,820.29	69,540,142.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,132,740.00	69,269,424.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,161,600.00	52,110,051.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,971,140.00	17,159,373.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	602,080.29	270,718.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	602,080.29	270,718.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	52,585,929.42	34,324,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,585,929.42	34,324,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	52,585,929.42	34,324,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	52,585,929.42	34,324,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(52,585,929.42)	(34,324,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	123,144,810.01	19,329,581.53
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	68,136,191.87	191,281,001.88
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	191,281,001.88	210,610,583.41

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,812,268.15	573,006,763.86	116,043,072.37	901,862,104.38
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,812,268.15	573,006,763.86	116,043,072.37	901,862,104.38
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	185,407,850.19	185,407,850.19
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,812,268.15	573,006,763.86	301,650,922.56	1,087,469,954.57
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	212,812,268.15	573,006,763.86	301,650,922.56	1,087,469,954.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,961,920.00	1,961,920.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,812,268.15	573,006,763.86	303,612,842.56	1,089,431,874.57
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(1,961,920.00)	-	(1,961,920.00)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	33,941,561.24	33,941,561.24
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,812,268.15	571,044,843.86	337,554,403.80	1,121,411,515.81

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,839,681,900.00	1,637,825,381.30	201,856,518.70	89.03
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,485,647,700.00	1,474,335,400.00	11,312,300.00	99.24
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,485,647,700.00	1,474,335,400.00	11,312,300.00	99.24
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	161,254,700.00	160,983,981.30	270,718.70	99.83
132001	Орон нутгийн төсвөөс	161,254,700.00	160,983,981.30	270,718.70	99.83
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	192,779,500.00	2,506,000.00	190,273,500.00	1.30
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,506,000.00	2,506,000.00	-	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	190,273,500.00		190,273,500.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,839,681,900.00	1,618,495,799.77	221,186,100.23	87.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,839,681,900.00	1,618,495,799.77	221,186,100.23	87.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,769,010,800.00	1,549,226,375.77	219,784,424.23	87.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,317,971,000.00	1,131,356,359.81	186,614,640.19	85.84
210101	Үндсэн цалин	788,518,800.00	670,557,689.72	117,961,110.28	85.04
210102	Нэмэгдэл	480,020,300.00	390,145,409.66	89,874,890.34	81.28
210104	Урамшуулал	49,431,900.00	70,653,260.43	(21,221,360.43)	142.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,746,500.00	132,968,636.66	31,777,863.34	80.71
210201	Тэтгэврийн даатгал	112,027,600.00	89,707,968.49	22,319,631.51	80.08
210202	Тэтгэмжийн даатгал	13,179,700.00	11,354,195.16	1,825,504.84	86.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,589,900.00	5,562,384.45	1,027,515.55	84.41
210204	Ажилгүйдлийн даатгал	6,589,900.00	5,070,742.69	1,519,157.31	76.95
210205	Эрүүл мэндийн даатгал	26,359,400.00	21,273,345.87	5,086,054.13	80.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,254,700.00	155,983,981.30	270,718.70	99.83
210301	Гэрэл, цахилгаан	13,125,700.00	11,775,069.30	1,350,630.70	89.71
210302	Түлш, халаалт	140,129,000.00	140,128,912.00	88.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	4,080,000.00	(1,080,000.00)	136.00
2105	Нормативт зардал	32,987,400.00	27,987,400.00	5,000,000.00	84.84
210502	Хоол, хүнс	32,987,400.00	27,987,400.00	5,000,000.00	84.84
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,407,900.00	25,305,600.00	(3,897,700.00)	118.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,506,000.00	2,506,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,901,900.00	22,799,600.00	(3,897,700.00)	120.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,643,300.00	70,624,398.00	18,902.00	99.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,387,900.00	63,257,098.00	130,802.00	99.79
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,255,400.00	7,367,300.00	(111,900.00)	101.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,671,100.00	69,269,424.00	1,401,676.00	98.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,671,100.00	69,269,424.00	1,401,676.00	98.02

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,334,400.00	52,110,051.00	1,224,349.00	97.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,336,700.00	17,159,373.00	177,327.00	98.98
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		191,281,001.88		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		210,610,583.41		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 104,629.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Тусгай зориулалтын материалын дансанд 37,774.2 мянган төгрөгийн сургуулийн үдийн хоол болон дотуур байрны хоолны хүнсний материалыг бүртгэсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайлан 880.6 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, 5.907.3 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал, 4,430.9 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлыг тус тус бусад зардлаар тайлагнасан.

Бараа материалын тайланд 9,479.5 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын 2025 оны А/13 дугаар тушаалаар акталж данснаас хасахдаа хөрөнгө устгасан акт, баримтад хавсаргаагүй.

Тайлант оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 270.7 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн санхүүжилтийн орлогод тохируулаагүй.

Боловсролын газраас шилжүүлэн өгсөн үндсэн хөрөнгийг худалдан авснаар, үнэ шинэчлэн тогтоохоор зарлагдсан хөрөнгийн акталсан хөрөнгөөр нийт 43,931.8 мянган төгрөгийг бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-д "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн 10,365.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 16,413.8 мянган төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 10,365.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

**Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Тайлант оны эцэст Ерөнхий боловсролын сургуулийн даргын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн тушаалаар 22 багш, ажилчдад гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас олгож, Нийгмийн даатгалын шимтгэлийн 4,160.7 мянган төгрөг суутгаагүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэлийн хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна", 19.1.3-д "ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант хугацаанд 22 ажилтанд олгосон гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас суутгах 4,160.7 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг холбогдох албан тушаалтнаар суутган тайлагнах.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд гэрэл цахилгааны зардлаас цэвэр бохир усны зардалд 640.0 мянган төгрөгийн зардлыг гүйлгээг гаргасан.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэлийн хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвөөс зардал гаргахдаа Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангилал ашиглах зааврыг ашиглан давтан гаргахгүй ажиллах.

4. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Өмнөх оны 3,691.7 мянган төгрөг өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй, тайлан оны эцэст шинээр үүссэн хүнсний материалын 1,876.6 мянган төгрөг, нийт 5,568.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "оршин байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 37 ширхэг 27,713.2 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тусгай зориулалтын материалын дансанд 37,774.2 мянган төгрөгийн сургуулийн үдийн хоол болон дотуур байрны хоолны хүнсний материалыг бүртгэсэн.	1	37,774.2			1	37,774.2	1	37,774.2		
2	Санхүүгийн үр дүнгийн тайлан 880.6 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, 5,907.3 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал, 4,430.9 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардлыг тус тус бусад зардлаар тайлагнасан.	1	11,128.9			1	11,128.9	1	11,128.9		
3	Бараа материалын тайланд 9,479.5 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын 2025 оны А/13 дугаар тушаалаар акталж данснаас хасахдаа хөрөнгө устгасан акт, баримтад хавсаргаагүй.	1	9,479.5			1	9,479.5	1	9,479.5		
4	Боловсролын газраас шилжүүлэн өгсөн үндсэн хөрөнгийг худалдан авснаар, үнэ шинэчлэн тогтоохоор зарлагдсан хөрөнгийн акталсан хөрөнгөөр нийт 43,931.8 мянган төгрөгийг бүртгэсэн.	1	43,931.8			1	43,931.8	1	43,931.8		
5	Тайлант оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн 270.7 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн санхүүжилтийн орлогод тохируулаагүй.	1	270.7			1	270.7	1	270.7		
	Дүн	5	102,585.1			5	102,585.06	5	102,585.06		

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1					
2	Тайлант хугацаанд гэрэл цахилгааны зардлаас цэвэр бохир усны 640.0 мянган төгрөгийн зардлын гүйлгээг гаргасан.	1	640.0					1	640.0				
3	Тайлант оны эцэст Ерөнхий боловсролын сургуулийн даргын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн тушаалаар 22 багш, ажилчдад гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас олгож, Нийгмийн даатгалын шимтгэлийн 4,160.7 мянган төгрөг суутгаагүй олгосон байна.	1	4,160.7					1	4,160.7				
4	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 37 ширхэг 27,713.2 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.	1						1					
5	Өмнөх оны 3,691.7 мянган төгрөг өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй, тайлан оны эцэст шинээр үүссэн хүнсний материалын 1,876.6 мянган төгрөг, нийт 5,568.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.	1	5,568.3					1	5,568.3				
	Дүн	5	10,365.1					5	10,365.1				

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 139 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 10 мэдээлэл, байршуулаагүй 22 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас зарлагын 155,311.1 мянган төгрөгийн 11 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 1,522,612.5 мянган төгрөгийн 51 гүйлгээ, зарлагын 56,958.9 мянган төгрөгийн 7 гүйлгээ байршуулаагүй. Мөн худалдан авах ажиллагааны тайлан, эхний хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан болон шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.	1	1,734,882.5			1	1,734,882.5		-
Дүн	1	1,734,882.5			1	1,734,882.5		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд 31,740.0 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авалт хийхдээ тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн.	1	31,740.0					1	31,740.0
Дүн	1	31,740.0					1	31,740.0
Нийт дүн	2	1,766,622.5			1	1,734,882.5	1	31,740.0

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 40-20810579-ТӨА-2026/081/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 139 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 10 мэдээлэл, байршуулаагүй 22 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас зарлагын 155,311.1 мянган төгрөгийн 11 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 1,522,612.5 мянган төгрөгийн 51 гүйлгээ, зарлагын 56,958.9 мянган төгрөгийн 7 гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан, эхний хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан болон шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.2-т “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.10-т “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах зөрчлийг давтан гаргахгүй, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Сүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Р.Гэрэлсайхан, нягтлан бодогч Ч.Буджав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ХИШИГЖАРГАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn